



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-26

1.Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	5-14
2.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	14-26

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Энхнасан, Д.Энхтүвшин;
Чөлөөтэй: П.Наранбаяр, Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, С.Лүндэг, Р.Эрдэнэбүрэн;
Тасалсан: О.Амгаланбаатар, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр.

Нэг.Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мэргэжилтэн Д.Ариунтуул, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, мөн эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Нандинцэцэг, Зүрх судасны зөвлөх, Люксембургийн хөгжлийн агентлагийн Салбар хариуцсан ахлах зөвлөх Д.Мөнгөнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, С.Эрдэнэболд, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар

сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн мэргэжилтэн У.Марал, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга Н.Нарангэрэл, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Баянмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Санхүүжилтийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Х.Жангабыл, Н.Батсүмбэрэл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн

сайд Ж.Чинбүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 14 цаг 55 минут

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажыкбэрийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Ганбатын Хосбаярын гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны ирц бүрдсэн байна аа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

Эхний асуудал Монгол Улс болоод Европын сэргээн босголт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Хоёр дахь асуудал нь Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг дэх асуудал. Монгол Улс болон Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийг Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Энхбаяр сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлд Зүрх судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулна гэж Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 3 дугаар зүйлд Зүрх судасны үндэсний төвийг барих гэж тус тус заасан.

Үүний дагуу Засгийн газраас дээрх төслийг Европын Сэргээн босголт Хөгжлийн банкны 34.9 сая ам.долларын зээл болон Люксембургийн Их Гүнт улсаас олгох 26.3 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Улсын Их Хурлын Эдийн засаг төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо танилцуулж зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох Ерөнхий сайдын захирамжийн төслийг дэмжсэнээр 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зээлийн гэрээнд гарын үсэг зураад байна аа.

Төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх судасны эмнэлгийг барих шинээр барьж тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчлөл нас баралтын хэмжээг бууруулах өндөр ач холбогдолтой байна аа.

Тус зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул техник хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр Шадар сайдад баярлалаа.

Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, тус яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Солонгын Тулга, Жамьяншаравын Дэлгэржаргал тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бат-Эрдэнийн Хулан Сангийн дэд сайд, Лувсандоржийн Гантогтох тус яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Дашдэлгэрийн Ариунтуул Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна. ЭМЯ-аас Жигжидийн Чинбүрэн сайд хүрэлцэн ирсэн байна. Мөн ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү хөрөнгө оруулалт хэлтсийн дарга Нямдэлгэрийн Хүрэлбаатар хүрэлцэн ирсэн байна.

Улсын 3 дугаар эмнэлгээс тус эмнэлгийн захирал Цэдэн-Очирын Түмэн-Очир дарга ирсэн байна. Мөн Болдбаатарын Нандинцэцэг тус эмнэлгийн эмнэл зүй эрхэлсэн дэд захирал, Дагвын Мөнгөнчимэг тус эмнэлгийн Зүрх судасны зөвлөх, Люксембургийн хөгжлийн агентлагийн салбар хариуцсан ахлах зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна аа. Уг зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Намар орж ирсэн бид нар бас дэмжээд явуулсан. Тэгээд ерөнхийд нь дэмжиж байгаа. Тэгэхдээ ганц нэг тодруулчих юм байна. Энэ хугацааны хувьд наашлуулах ганц нэг жилийн наана ч гэсэн хэрэгжиж дуусах боломж байх уу. Энэ талаар ер нь судалгаа хийсэн цаад газартайгаа ярьж байгаа зүйл байгаа юу?

Хоёрт нь ер нь бид нар ингээд зээл авч байна. Өнөөдөр ингээд валютаар орж ирээд л Монгол төгрөгт хөрвөөд л бүтээн байгуулалт болчихож байна. Төсөл хэрэгжчихэж байна. Эргээд 10 жилийн дараа 20 жилийн дараа төлөхдөө валютаар төлнө. Энэ хоорондох ханшийн зөрөө магадгүй тэр ирээдүйд 10 жил 15 жилийн дараа төлөх үед төсөв дээр суухдаа Монгол төгрөгөөр сууна. Тэгэхээр энэ ханшийн зөрөөг ер нь ямар үндэслэлээр яаж тооцдог юм. Тэгээд ирээдүйд бас л 10, 15 жилийн дараа төсөв дээр дарамт үүсэх, төсөв дээр их дүнтэй төлбөр суугдах зэрэг ийм асуудлууд гарах байх л даа. Тэгэхээр энэ дээр ер нь яг энэ Сангийн яам ямар мэдээлэл өгөх вэ?

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яамнаас хариулъя хэн хариулах вэ? 7 номер.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариулъя. Люксембургийн Их гүнт улсаас энэ төсөл дээр 26 сая долларын буцалтгүй тусламж өгч байгаа. EPR -аас авч байгаа зээлийн хэмжээ 34 сая доллар. Ингээд нийт эх үүсвэрийг тооцоод үзэхээр манай Өрийн удирдлагын тухай хуулийн нэн хөнгөлөлттэй гэдэг энэ ангилалд ингээд багтаад явж байгаа. Эргэн төлөлтийг валютаар хийнэ. Тэгээд зээлийн хэмжээнд авч байгаа эх үүсвэр маань нийтдээ нэн хөнгөлөлттэй эх үүсвэр явж байгаа учраас яг эргэн төлөлтөөр хэдий чинээний хөнгөлөлт орж ирээд ингээд явж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя аа. Ер нь аль болохоор хурдан хийх бидэнд хэрэгцээ өндөр шаардлага их байгаа гэдэгт бол яг тантай санал нэг байгаа. Бид аль болох хурдан хийх. Тэр утгаараа төслийн нэгж дээрээс нь энэ чинь олон улсын тендер зарлагдана. Барилгын сонгон шалгаруулалт гээд нэлээдгүй ажлууд явна. Аль болох л цэгцтэй зөв зохион байгуулах. Мөн энэ ажлын хэсгийг санхүүжүүлэхээр буцалтгүй тусламжаар Европын Сэргээн Босголтын банкнаас санхүүжилт гаргаж тэгээд Люксембургээс өөрснөө ахалж энэ ажлыг удирдан зохион байгуулахаар ярьсан байгаа. Тийм учраас бид аль болох л будилаан багатай хурдан шуурхай хийх энэ ажил явагдахын төлөө хичээж ажиллана аа.

Тэгээд 1 жил ч гэсэн бидэнд маш чухал байгаа. Үүний дараагаар яригдах энэ ADB-ийн төсөлтэй холбоотой энэ ерөөсөө хоорондоо уялдаатай төслүүд яваа юм. Тухайлах юм бол энэ зүрх судасны том төв бол ахисан шатын хүнд улсуудыг эмчилдэг. Нөгөө төсөл нь бол анхан шатны.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах уу? Болсон уу? Хосбаяр гишүүн. Эрдэнэболд гишүүн, асуулт асууя.

С.Эрдэнэболд: Уг нь энэ хэлэлцэж байгаа асуудлыг дэмжиж байгаа өмнө нь орж ирэхэд нь илэрхийлж байсан. Тэгээд өмнө нь асуусан зүйлийг дараагийн шатдаа илүү тодорхой болгоод оруулж ирье гэж тухайн үед ярьж байсан. Тэгээд тэрийг дахиад тодруулчихъя. Энэ нөгөө симуляц хийх буюу одоо энэ зээлийн дагуу эмнэлэг маань үйл ажиллагаагаа явахаар хэчнээн төгрөг Монголдоо үлдэх вэ? Дээрээс нь эрүүл мэндийн энэ чанар үйлчилгээ хэдэн хувиар яаж ахих вэ гээд өмнө нь 30 орчим хувиар ахина гэж байсан л даа. Тэгээд энэ дээр бол тодорхой судалгаа хийнэ гээд тэгж байсан.

Хоёрдугаарт нь Энхбаяр сайдаа энэ миний ойлгож байгаагаар бол орон нутгийн 6 бүс байгаад байгаа юм. Улаанбаатартайгаа нийлээд 7 нэгж бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд бид нар нэг яриад энийг мөрийн хөтөлбөртөө уяад ингээд яваад байгаа гэж ойлгож байгаа. Миний санаж байгаагаар АН, Ардын нам 2-ын мөрийн хөтөлбөрийн дотор байгаа эрүүл мэндтэй холбоотой бүсчилсэн хөгжил дэх эрүүл мэндтэй холбоотой хөрөнгө оруулалт нь бол бараг усны дусал шиг адилхан байсан.

Тэгэхээр одоо жишээлбэл Улаанбаатар хотод энэ төсөл хийгдээд явлаа гэхэд нөгөө бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр Бүсүүдийн төвд Улаанбаатар хотоос чанарын хувьд ойролцоо тийм хүртээмжтэй анагаах ухааны дэд бүтцийг зөөлөн дэд бүтцийг болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ гэсэн зохицуулалт зорилт байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь ингээд улсын хүрээнд том зургаараа харахаар яг хэчнээн хэмжээний ийм мөнгөн нэгжээр хэмжигдэх хөрөнгө оруулалт Монгол Улсад хэрэгтэй бөгөөд энэ нь зөвхөн Улаанбаатар хотод 3 дугаар эмнэлэг дээр түшиглээд барьж байгаа энэ төслийн цаана 6 бүсийн төвүүд дээр ингээд хийгдэх төсөл ер нь ямар хэмжээний хөрөнгө оруулалт байж байж яг энэ чиглэлийн эрүүл мэндийн жишээлбэл жишээ татахад энэ зүрх судасны асуудлыг шийдэх вэ? Бид нар нөгөө том зургаар нь ойлгомоор байгаа юм. Бусдаар бол энэ эрүүл мэндтэй холбоотой боловсролтой холбоотой яаралтай орж ирж байгаа асуудлуудыг бид нар ингээд л дэмжээд л дэмжээд л явчхаж байгаа юм. Гэхдээ том зургаар нь асуудлыг хармаар байгаа юм.

Дараад нь болохоороо энэ ер нь бол нөгөө энэ халдварт бус 4 төрлийн өвчлөлийн нэг нь зүрх судасны асуудал байгаад байгаа бол нөгөө 3 асуудал буюу Монгол Улсын иргэдийн нас баралтын зонхилох шалтгаан болоод байгаа бусад асуудлыг бууруулахад чиглэсэн гадаадын зээл тусламж магадгүй хөрөнгө оруулалттай холбоотой төсөл хөтөлбөрүүд оруулж ирэх үү. Энэ 2 асуултад хариулт авъя аа.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Яг л тогтолцооны хувьд яг л зөв асуулт асуугаад байгаа юм. Ер нь аливаа улсын эрүүл мэндийн бодлого нас баралтыг бууруулах хамгийн нас баралтын гол шалтгаан болж байгаа өвчтөнүүдтэйгээ хэрхэн тэмцэх вэ гэдэг бодлого 1 дүгээрт л байх ёстой. Энэ чиглэлд ерөөсөө Монгол Улсад нас баралтын гол шалтгаан бол зүрх судасны өвчин. Энэ нийт нас баралтын 25 хувийг дангаараа эзэлж байгаа. Дараа нь хорт хавдар энэ 20 хувийг эзэлдэг. Тэгэхээр ерөөсөө бид энэ аварч болох нас баралт гэдэг нэр томьёог бид ЭМЯ-аас нэлээдгүй ярьж байгаа. Аварч болох сэргийлж болох нас баралтыг ингээд яг манай салбарын судлаачдын жил болгон нас барж байгаа хүний тоон дээр өвчний ангилал дээр задлаад шинжлээд үзэхлээр 6 мянга гаруй нь буюу 3-ны 1 нь аварч болох нас баралт байна. Жилдээ бид чинь 18200-18300 орчим хүн нас барж байна. Тэгэхэд энэний 3-ны 1 гэдэг маань 6 мянган иргэдээ бид хэрвээ тусламж түргэн очоод мэргэжлийн тусламж үзүүлж чадах юм бол аварч болох хүний тоо 3-ны 1 нь байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энийг энэ чиглэлд бид хийх гэж байгаа нэг том ажил энэ зүрх судасны төвийн ажил.

Хоёр дахь чухал зүйл бол бид 21 аймагт түргэн тусламж түргэн очоод тээвэрлэлтийн явцад зөвлөгөө мэдээлэлтэйгээр веб камерын зөвлөгөөтэй тогтмол интернэттэй ийм зөвлөх баг Улаанбаатар хотод колл центр дээр ажиллаад тээвэрлээд аймаг бүрийн эмнэлэг дээр тэр зүрхний шигдээс болсон бол бүлэнг нь хайлуулах, судсан дотуур бөглөөг нь гаргах. Хэрвээ харвалт болсон харвалтын шалтгаан цус алдсан бол хагалгаа хийгээд тэрийг нь доор нь тогтоочихдог байх. Гэмтэл осол жилдээ бид 600 гаруй иргэдээ алдаж байгаа. Гэмтэл ослын тусламжийг шуурхай хүргэдэг.

Дээрээс нь хамгийн чухал нь хүүхдийн эрчимт эмчилгээ сайжруулах гэсэн ийм том төсөл. Бас энэний дараа та бүгдээр соёрхон батлуулахаар орж байгаа. Энэ 21

аймагт аймаг бүрийн чадавхыг сайжруулах хүний нөөцийг бэлдэх түргэн тусламжийн сая хэлдэг машин тоног төхөөрөмж интернэтэд суурилсан ийм тусламжтай том төвүүдийг хийхээр энэ төлөвлөж байгаа. Энэ төсөл маань өөрөө сая хэлсэнчлэн зүрх судасны төвөөс гадна одоо хэрэгжиж байгаа DB-ийн том төсөл байгаа. Энэ түргэн тусламжийн колл центрийн төв байгуулж байгаа. Энэ ажил явж байгаа. Нэг ёсондоо энэ 3 төсөл хоорондоо дандаа уялдаатай холбоотой бие биеийгээ нөхөж дэмжсэн.

Тэгэхээр анхан шатын тусламж үйлчилгээгээр бид яаралтай тусламжийг сайжруулаад аймагт нь тогтворжуулаад бүүр ахисан шатын эмчилгээ шаардлагатай болох юм бол Улаанбаатар хотод одоо яригдаж байгаа Европын сэргээн босголтын банкны тал хувийг нь энэ зээлээр хийх гэж байгаа. Энэ төв дээр ирж дараагийн шатын ахисан шатын эмчилгээнүүдээ хийлгэх аврагдах ийм боломж нь бүрдэнэ. Бид бас ганцхан яаралтай тусламж гэхээс гадна зүрх судасны өвчнүүд архаг тэгсэн хэрнээ ахисан шатын тусламж үйлчилгээ хэрэгтэй зүйлүүд байж байна. Тухайлах юм бол хэм алдалттай үед нь янз янзын аппаратууд суулгаж байна. Пийс Мэйкерүүд гэж бид нэрлэдэг. Дээрээс нь хэм алдалттай үед илүү голомтуудыг нь төлж идэвхгүй болгох ч гэдэг юм уу. Дээрээс нь зүрх шилжүүлэн суулгах эмчилгээ хүртэл Монгол Улсад нэвтрээгүй байх жишээтэй.

Ингээд энэ ахисан түвшний эмчилгээнүүдээ Европын Сэргээн Босголтын банкны санхүүжилтээр ингээд хийхээр ингээд ерөнхийдөө бид энэ нас баралтыг 40 хувь буулгаж саяын сэргийлж болох нас баралтыг 40 хувь буулгах ийм том зорилтыг тавьж байгаа. Энэ маань бараг 2400, 2500 хүмүүсийг аварна гэсэн ийм том зорилго. Тэгэхээр энэ тогтолцоо бүрдээд 2028 оноос эхлээд энэ ажиллаж эхэлнэ гэж харж байгаа юм. Энэ тогтолцоогоор.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн, нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгээд би санааг нь ойлгоод байгаа юм сайд аа. Тэгэхдээ яах вэ тодорхой асуугаад байгаа зүйл болохлоор 1 дүгээрт бүсчилсэн хөгжил гээд бид нар чинь баахан юм болчихсон. Бүсчилсэн хөгжлийн чинь тэр үзэл баримтлал сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газрын үзэл баримтлал би хэвээрээ явж байна гэж ойлгож байгаа. Нөгөө хурдтай хөгжлийн төлөөх зориг шинэ итгэл шинэ юу билээ эрс шинэчлэл гээд. Тийм тэгэхдээ миний ойлгож байгаагаар бол Энхбаяр сайдын удаа дараагийн хэлж байгаагаар бол энэ бүсчилсэн хөгжлийн концепц чинь хэвээрээ байгаад байгаа юм байна гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээрээ нөгөө та сая 21 аймаг ярьж байна шүү дээ? Сайн байна. Тэгэнгүүт энэ бүсчилсэн хөгжлийн яг тэр 6 төвүүд болсон тэр дээр арай илүү өндөр шатлалын эмнэлэг байх юм байна. Гэхдээ Улаанбаатарт байгаа эмнэлгээс дутахгүй тэр иргэдэд хүний эрүүл амьдрах эрхийнх нь дагуу тэр хүртээмжийг нь сайжруулах юм байна. Энэ рүү хөрөнгө оруулалт зайлшгүй юм байна. Энэ хөрөнгө оруулалтын хэмжээ ер нь ямаршуухан байгаа хэмжээтэй яригдах вэ? Тэрнээс одоогийн ярьж байгаа жишээлбэл энэ төсөл ер нь хэчнээн хувьд нь.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн, нэмж гүйцээгээд асуулт асууя?

С.Эрдэнэболд: Энэ дээр ямар нэгэн симуляц байна уу гэж би өмнөх орж ирэхэд асууж байсан байхгүй юу. Тэгээд тэр симуляц зайлшгүй хэрэгтэй. Ингэснээрээ яаж байна гэхээрээ иргэдийн нөгөө мэдэх эрх хангагдана. Ядаж засгийн явуулаад байгаа энэ бодлого, эрүүл мэндийн бодлого, дээрээс нь яагаад

энэ зээл тусламж чинь зайлшгүй юм бэ гэдгийг ойлгох Чинбүрэн сайд аа, би дэмжиж та бүхний аргументийг дэмжиж энэ асуултыг асуугаад байгаа юм. Тэгээд нөгөө утааны сонсголын үеэр танай яамны ТНБД-ын хэлсэнчлэн Монгол хүмүүсийн түгээмэл нас бараад байгаа шалтгаант нөхцөлүүдийг судалдаг лаборатори зайлшгүй хэрэгтэй юм байна аа. Урд улс бол энийг ойролцоогоор 100 сая долларт багтааж хийх ийм судалгаа хийгдсэн юм байна гэж ярьсан. Тэгэхээр одоо яаж байна гэхээрээ бид нар нэг энэ улсдаа нэг ийм лаборатори байгаад ер нь амаар мэдээд байгаа шүү дээ. Ерөнхийдөө зүрх судас тэдэн хувьтай гээд байгаа ч гэсэн яг цаад талын байгаа шалтгаант нөхцөл нь нарийн судалдаг лаборатори суурьтай ийм центр хэрэгтэй байгаад байна гэсэн.

Тэгэхээр энийг жишээлбэл төсөвт оруулах уу, яах вэ, ийх вэ гээд хоёулаа ярьж ярьж байсан шүү дээ гэх мэт зургаар цогцоор нь харах тал дээр л мэдээлэл өг.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Бид Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа баталсан. Тэр хуулийнхаа дагуу Монгол Улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр буюу дунд хугацааны 2026-2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрөө сая бид оны өмнө баталсан. Одоо энийгээ задлаад жил жилийн нэг жилийн төлөвлөгөөнүүдээ батална. Энэ бодлогын хүрээнд төсвийн хүрээ энэ хаврын чуулганд орж ирж батлагдана. Тэр төсвийн хүрээнд үндэслээд төсөв зохиогдож намар өргөн баригдана. Тэгэхээр энэ төсвийн бодлого төлөвлөлтийн хууль нэлээн чанга хууль. Төсвийн сахилга батыг нэлээн сайжруулах, төрийн хөгжлийн бодлогыг тогтвортой байлгах үүднээс хийгдсэн. Аливаа улс төрөөс хамаарч бодлого өөрчлөгдөхгүй байна гэдэг зорилгын хүрээнд олон жилийн улс төрийн намуудын зөвшилцлийн үр дүнд бий болсон хууль юм байгаа юм.

Ингээд хийх ажил хөгжүүлэх салбарууд төслүүд бүгд ба хуульчлан батлагдсан. Бид энэ 5 жил тэр хүрээнд энэ дотор л ажиллана. Шинээр аливаа шинэ хөтөлбөрийг оруулах гарах асуудал нэлээн босго өндөртэй. Зөвхөн ТЭЗҮ нь хийгдсэн. Эдийн засгийн үр ашигт байдал нь тодорхой болсон, улсын төсөв буюу гадаадын зээл тусламж нь эх үүсвэр нь олдсон ийм төсөл хөтөлбөрүүд л хэрэгжихээр нэлээн санхүүгийн сахилга баттай болгож байгаа. Тэр байтугай сонгуульд дэвших, нэр дэвшигч нар ерөнхийлөгч ч бай, улс төрийн намууд ч бай зөвхөн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нийцүүлж сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж оруулна.

Хэрвээ үүнээс гажсан нийцээгүй хөгжил бодол сонгуулийн хөтөлбөр оруулж ирвэл тухайн улс төрийн намыг сонгуульд нэр дэвшилтээс нь хасах хүртэл ийм хатуу зохицуулалттай юм байгаа юм. Тэгэхээр одоо бид 26-аас 30 онд хийх энэ 5 жилийн хөтөлбөр дотроо л хөгжлийнхөө бодлогыг ярьж, төсөв мөнгөө хүрээлж, энэ дээрээ тооцоо хийгээд явна шүү л гэж байна. Эрүүл мэндийн сайд талаасаа салбар талаасаа Чинбүрэн сайд хариулъя гэж байна.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Ер нь Засгийн газрын бүсчилсэн хөгжлийн бодлого хэвээрээ байгаа. Гэхдээ эрүүл мэндэд онцлог зүйлүүд байна. Хуучин бид энэ бүс Бүсийн оношилгоо эмчилгээний төв байгуулж байсан гол шалтгаан бол аймаг болгонд бид өндөр өртөгтэй тэр тоног төхөөрөмжүүдийг суурилуулж чадахгүй эдийн засгийн

хувьд хязгаарлагдмал байсан учраас иргэдийг бүсчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ чанартай авахын тулд ингээд бүсчилж хөрөнгө оруулалтуудыг хийж байсан. Өнөөдрийн нөхцөл байдал өөр болсон. Өнөөдөр бид бүсчилсэн хөгжлийг ярихдаа эрүүл мэндийн салбарынх арай өөр. Бид 20 минутын хот гэж яриад байгаатай адилхан эмнэлгийн тусламжийг хамгийн ойрхон ялангуяа энэ яаралтай тусламжийг хамгийн ойрхон эмнэлэгтээ очиж авдаг байх. Хаана амьдарч байгаагаасаа үл хамааран амьд явах эсэхээ шийдүүлж болохгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь хүний эрхийн хамгийн чухал зүйл. Тийм учраас бид энэ бүсчилсэн бодлогоосоо эрүүл мэндийн тусламжийн илүү аймаг бүрд тусламж хүрдэг байх ийм тогтолцоог хийж өгөх гээд энэ бодлого өөрчилж.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгээд яах вэ би Энхбаяр сайд болон Чинбүрэн сайд аа. Энэ Жавхлан сайд, ер нь би дэмжээд байгаа юм. Тэгэхдээ илүү нөгөө ойлгомжтой байх үүднээс яагаад гэхээр нэг талдаа бол бүсчилсэн хөгжлийн чинь бодлого дээр болохоороо яг таны ярьж байгааг эсрэгээр биччихсэн байгаа шүү. Яг эсрэгээр нь биччихсэн байгаа. Салбарын сайд нь болохлоороо яг нөгөө талаас нь яриад байна. Тэгээд энэ чинь аягүй тийм миний хувьд ойлгомжгүй зүйл болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг нөгөө нэг бол жишээ нь сая Тэргүүн Шадар сайд болохоороо бүсчилсэн хөгжлийн бодлого бол яг хэвээрээ энүүгээр явна гэж байгаа. Тэгэнгүүт ... хувьд энэ шал өөр нөхцөл байдал үүсчихнэ гэж би ойлгоод байна. Би эргэлзээд байж магадгүй буруу ойлгосон байж магадгүй.

Тэгэхээр энэ мэт ойлголтуудаа сайхан дэлгэрэнгүй өгөөд явбал зөв байна аа. Тэгээд нөгөө та 2025 оны 2 сарын 3, 4-ний өдрүүдэд утааны сонсголыг удирдсан тэрүүгээр чинь баахан юмнууд гарчихсан. Одоо нөгөө араас нь хийгдэх ажил дахиад л нэхэгдэж байгаа. Тэн дээр ярьж байсан ЭМЯ-ны байр суурь сайд нь өөрчлөгдсөн ч гэсэн цаашаа явах ёстой л гэсэн байр суурийг хэлье дээ тэгээд зарчмын хувьд энийг дэмжиж байна аа.

Г.Тэмүүлэн: Тэргүүн шадар сайд Ж.Энхбаяр.

С.Эрдэнэболд: Эрдэнэболд гишүүн тантай санал нэг байгаа юм. Бид нөгөө Монгол Улсын нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ 5 жилээ баталчихсан. Тэр баталсан бодлого маань өөрөө төвлөрлийг сааруулах бүсчилсэн хөгжүүлэх тэр үзэл санааг дотроо шингээж байгаа юм. Сая Чинбүрэн сайд хэлдэг нь эрүүл мэндийн салбар арай өөр онцлогтойгоор эрүүл мэндийн тусламж үзүүлэх чадавхыг 21 аймагт жигд бий болгоно оо. Энд эдний яриад байгаа тэр чадавх бий болгох бодлого нь энэ 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл дотор бодлогоороо тусчихсан байхгүй юу. Бүсчилсэн хөгжилтэй холбоотойгоор жишээлбэл юу гэдэг юм таны сонгогдсон тойрогт бүсийн 2 дугаар зэрэглэлийн том улсын чанарын 2 дугаар том эмнэлэг ажил эхэлчихсэн явж байгаа. Энэ 2027 он гэхэд ашиглалтад орохоор. Энэ бичлэгээс нэг талаас нь аваад ингээд шийдээд 27 буюу нэгдсэн 1, 2, 3, 4 дүгээр эмнэлэг гэдэг шиг.

Г.Тэмүүлэн: Гишүүд зээлийн хэлэлцээртэй холбогдуулж асуулт асуулаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Яах вэ саяын харилцан ярианаас болохоор нэг юм үлдээд байгаа нь юу вэ гэхээр миний нөгөө гол асуух гээд байгаа санаа юу байсан гэхээрээ одоо жишээлбэл энэ онцгойгийн салбарт 1.2-ын их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байхад бүхий л нутаг дэвсгэр дээр хүртээмжтэй тэр иргэдийг аврах тэр нэгжүүдийг байгуулах боломжтой гэнгүүт би ойлгочхож байгаа байхгүй юу. 1.2 их наяд дотор нь юу юм бэ гээд ингээд соортлоод ойлгочхож байгаа юм. Яг үүнтэй адилхан эрүүл мэндийн салбар дахь таны зориод байгаа Засгийн газрын дэвшүүлээд байгаа тэр бодлогыг бүхэлд нь хатуу дэд бүтцийг нь тэр софтвертэй нь шийдэхийн тулд ямар хэмжээний хөрөнгө оруулалт ямар хугацаанд хэрэгтэй юм бэ? Тэр дотроо одоо энэ бид нараар орж ирж байгаа энэ хэлэлцэх асуудал чинь энэний нөгөө симуляц гэж хэлээд байгаа нь хэдэн хувьд нь энэ ажиллах юм аа.

Цаашлаад бид үлдсэн жишээлбэл юу гэдэг юм энэ хүний эрхийн асуудал учраас би асуугаад байхгүй юу даа. Цаашлаад энэ асуудлыг бүрэн дүүрэн хангахын тулд тийм үү? Эргээд монгол хүний таны хэлээд байгаачлан тэр аварч болох нөхцөл байдалд хүний амийг илүү яаж аврах вэ? Тэрэнд жишээлбэл ямар зохион байгуулалт, ямар бодлого, ямар хөрөнгө оруулалт, ямар дэд бүтэц хэрэгтэй вэ гэдгийг л бид нар бүтэн зургаар нь ойлгох гээд байгаа юм. Тэгснээрээ яах вэ гэхээрээ орж ирж байгаа төслүүдийг л дэмжээд явахаас ил гадна ер нь энэ том зургаараа бид нар чинь ийм хэмжээний хөрөнгө оруулалтыг эрүүл мэндийн салбартаа оруулахад логикоороо тэндээс тэд нь улсын төсвөөс тэд нь хувийн хэвшилтэй хамтраад энэ нь олон улсын дээд зээл тусламжаар ингээд явахад бол бид нар богино хугацаанд Монгол хүнийхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг төр Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой вэ гэдгийг л ойлгуулах ёстой. Нөгөө талаасаа жирийн иргэдэд ингээд зээл тусламж аваад л байдаг, аваад л байдаг, хаашаа юунд үр дүн зарцуулагдаад байдаг юм бэ гэдэг. Гэхдээ яг энэ эрүүл мэндийн салбар бол онцгой. Шууд энэ үр дүн нь ингээд хүний амь нас эрүүл аюулгүй байдлаар хэмжигдэж байгаа учраас тэгэхээр энэ зүйлийг л нэгэнт Байнгын хороогоор энэ хэлэлцэгдэж байгаа учраас гэрээ гэхээсээ илүүтэйгээр том зургаараа энэ дүнг л илэрхийлээсэй гэсэн ийм бодлоор би асуугаад байгаа юм.

Тэгэхдээ асуулт биш сая үг хэлчихлээ.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Чинбүрэн сайд анхаарч ажиллаарай. Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Үгүй бид нар ингээд сайн сайхан л юм яриад байгаа юм л даа. Энэ яриагаараа бараг цэнгэлийн манлайд хүрчихсэн ч юм шиг. Ийм л юм яриад байгаа байхгүй юу. Тэгээд л энд тэндээс зээл энээ тэрээ гээд л олж ирээд л соёрхон батлаад л. Тэгээд үр дүн нь хаана байна аа. Тэгээд энэ иргэд чинь одоо 5, 10 төгрөг байвал бүгдээрээ л гадагшаа явж байна шүү дээ. Эрээн дээр очиж байна, Хөх хот дээр очиж байна. Тэгээд виз нь гарвал Солонгост очиж эмчид үзүүлж байна. Тэгээд танай салбар болохгүй л байна шүү дээ. Тэр эмнэлэгт эмчлүүлж байгаа тэр нийгмийн даатгалынх нь сан, ЭМД-ын сан мөнгө төгрөгийг нь төлж чаддаггүй, дампуурчихсан юм уу яачихсан юм ийм нөхцөл байдалтай байна шүү дээ. Тэгээд л мөнгө цутгаад байдаг юм. Тантай бол хамаагүй байх. Энэ одоогийн байгаа дарга сайд нартай. Заримтай нь ч хамаатай байх. Нэг хэдэн жилийн өмнө энэ бүртгэлийг сайжруулъя гээд л НҮБ, ОУБ-аас овоо хэдэн төгрөг тавиад бүх газраас хүнд сурталгүй, чирэгдэлгүй, ийм байдаг больё гэсэн ийм төсөл хөтөлбөр хэрэгжээд явж байтал бас мөнгө төгрөг нэхээд авлига болоод л тэгээд л дууссан шүү дээ. Тэгээд нөгөө байгууллага нь юмаа татаад л. Дэлхийн банк. Ер нь та нарыг засаглаж байхад

нэг иймэрхүү юм болоод л иймэрхүү байдалтай л дуусах юм. Тэгээд энэ дээр бид нар болж байгаа бүтэж байгаа юм шиг гоё юм яриад л. Тэгээд нөгөө иргэддээ хүрдэггүй. Иргэдийн бахь байдаг байдал байдгаараа. Ийм байхад одоо тэгээд хариуцлага ярихгүй, үр дүн ярихгүй ийм байхад баахан мөнгө нэмж аваад л өр авлага нь ихсээд л. Одоо чинь юу вэ? Гадаад өр чинь 40 тэрбум хүрчихсэн гээ биз дээ. Ахиад ч хэд ч хүрээд байгаа юм. Ер нь больё больё. Энэ янз бүрийн зээл би дэмжихгүй байна.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд үг хэлье.

Ж.Энхбаяр: Миний хувьд энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа. Зүрх судасны асуудал манай Монгол иргэдийн нас баралтын гол шалтгаан. Зайлшгүй Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй жил болгон бурхны оронд очиж байгаа хүний тоо өндөр байгаа. Үүнтэй холбоотойгоор гадаадад явж эмчлүүлж байгаа гадагшаа урсаж байгаа мөнгөний тоо өндөр байгаа валютын тоо.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд манай эрүүл мэндийн салбарын ажлыг дүгнэх нэг л үзүүлэлт байгаа. 1990 онд Монгол хүний дундаж нас 58 байсан. Өнөөдөр 74. Бид энэ өнгөрсөн 35 жилийн хугацаанд энэ салбарын сайтай муутай ололт амжилтын үр дүнд Монгол хүн 16 жил дунджаар илүү амьдардаг болсон. Энэний цаана юу байгаа юм. Энэний цаана амьдралын чанар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ маш олон зүйлийг энэ цаана ярьж болно. Тэгэхээр энийг бүгдийг нь өнгөрсөн хугацааг харлуулахгүй үр дүнгүүд гарч байгаа урагшилж байгаа. Мэдээж сайжруулах боловсронгуй болгох ажлууд байлгүй яах вэ. Ингээд энийг та бид хамтраад л хийж бүтээж байгаа. Ялангуяа та бид 2 энэ Их Хуралд хамгийн олон суусан сайн муу гэвэл та бид 2-той л холбоотой. Сайн ч холбоотой муу нь ч холбоотой. Тэгэхээр бүгдээрээ энийг дэмжээд энэ иргэдийнхээ төлөө ингээд урагшлуулаад л явна. Нэг үеэ бодвол бид нар чинь юмаа ярьдаг, мэддэг, хянадаг, шалгадаг, сонсгол хийдэг л урагшлаад л байна шүү дээ.

Тэгэхээрээ таныг жоохон өөдрөг хандаад дэмжиж өгөхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулна. Гишүүд маань бас хангалттай ирцтэй байна. Гишүүд маань хариуцлагатай оролцоорой.

Энэ Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл маань өөрөө өнгөрсөн намар манай Байнгын хороогоор орж хэлэлцэгдэж байсан. Ингээд үндсэндээ 120 ортой эмнэлгийг бол өргөтгөлийг бол 3 дугаар эмнэлэг дээр нэмж барьж байгуулахаар байгаа. Өнөөдөр бид бүхэнд манай Байнгын хорооны гишүүдийн саналуудыг анхаарч үзээрэй. Сангийн яамныхан зээл тусламжтай холбоотой, түүний үр дүн, гүйцэтгэлтэй холбоотой хэрэгжилттэй хариуцлагатай холбоотой асуудлууд дээр ярьж байна. Гэхдээ мэдээж энэ бол эргээд улсын төсвөөс төлөгддөг учраас гишүүд тодорхой хэмжээнд энэ дээр бол шаардлага тавьж ажиллаж байгаа шүү. Бид нарын хувьд мэдээж эрүүл мэнд, боловсролын салбар бол мэдээж номер нэг.

Энэ үүднээсээ бид нар тэр дундаа хүн амын дунд өвчлөл дунд, нас баралт дунд хамгийн зонхилох өвчин болж байгаа зүрх судасны өвчтөнийг анагаах чиглэлээр урьдчилан сэргийлэх чиглэлээр өргөтгөл барьж байгаа нь өөрөө чухал асуудал байгаа. Энэ өөрөө зөвхөн эмнэлэг төвийн барилга барихаас гадна тоног төхөөрөмжийн шинэчлэлийн асуудлууд байгаа. Манай гадаад валютын урсгал

гадагшилж байгаа энэ нөхцөл байдал дээр тодорхой хэмжээнд саармагжуулах ийм үр дүнтэй ажил болох байх гэж бол хүлээлттэй байгаа. Тэгээд санал хураалтыг явуулъя.

Саналын томъёоллыг би та бүхэнд уншиж танилцуулъя. Санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт. Гишүүд хуруугаа хийгээрэй. Ингээд Санал хураалтыг Жаргалан гишүүн, ороогүй байна уу? Орчихсон уу? Санал хураалтыг явуулж эхэлье. Та бүхэнд томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улс болоод Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байна уу?

Санал хураалт.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Нийт хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн байна. Ингээд 70.6 хувиар дэмжигдсэн байна. Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Монгол Улс болоод Европын сэргээн босголт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд танилцуулах байгаа. Танилцуулах гишүүн байна уу? Очирбат гишүүн танилцуулна. Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийнхэнд баярлалаа. Төмөр-Очир даргад амжилт хүсье.

15.28 цаг

Хоёр дахь асуудалдаа орцгооё.

Дараагийн асуудал оръё.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ингээд уг хуулийн төслийн талаарх танилцуулгыг тэргүүн Тэргүүн Шадар сайд Ж.Энхбаяр сайд танилцуулна аа.

Ж.Энхбаяр: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны эрхэм дарга аа, Азийн хөгжлийн банкны 475 сая ам.долларын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг Улсын Их Хурлын эдийн засаг төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод танилцуулж хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгосны дагуу 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт гарын үсэг зураад байна аа. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан. Дараах төслүүдийг хэрэгжүүлнэ ээ.

Үүнд:

17 аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг өргөтгөж, шинэчилж, аймаг, бүрд яаралтай болон эрчимт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж 2 дугаар шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.Нийслэл орон нутгийн нэн шаардлагатай байршлуудад 32 сургууль, 9 цэцэрлэг барьж байгуулах бөгөөд ингэснээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын анги, төлөвлөлтийг бууруулна.

3.ХАА-н салбар дахь хүний нөөцийн ур чадварыг зах зээлтэй, эрэлттэй нийцүүлж мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн жишиг сургалтын тогтолцоог бий болгоно.

4.Онцгой байдлын байгууллагын гал түймэр, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлнэ ээ.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Энүүгээр Эрдэнэболд оо нөгөө аймгууд ч үндсэндээ ингээд шийдэгдэж байгаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Батсүмбэрэл Болормаа гишүүнээр тасалъя. Ажлын хэсэг. Түрүүн танилцуулснаар Сангийн яамныхан яг түрүүн адилхан байна. Бүрэлдэхүүн нь Боловсролын яамнаас Наранбаяр сайд байхгүй байна. Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Нямсамбуугийн Нарангэрэл тус яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга, Сономцэрэнгийн Должинсүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр нэмэгдэж орж байгаа юм байна. Бусад бүрэлдэхүүн нь. ОБЕГ-аас Ариунбуян дарга ирсэн байна. Төмөрбаатарын Мөнхдорж ОБЕГ-ын Санхүү, ар талын газрын дарга хурандаа Буянтогтохын Баянмөнх тус газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна аа.

Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Энэ л нэн хөнгөлөлттэй зээл аваад энэ асуудлаа шийдэх гэж байгаа. 2, 3 салбарын асуудлыг шийдэх гэж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ би нэг Эдийн засаг, хөгжлийн сайдаас асуух асуулт байгаа.

Бид нар яах вэ ер нь гаднаас орж ирж мөнгө орж ирж, энэ зээл тусламжаар орж ирж байгаа энэ санхүүжилтийн эх үүсвэрүүд маань бол нэн хөнгөлөлттэйгөөс

гадна бүтээн байгуулалт болохдоо гааль, НӨАТ зэрэг албан татваруудаас чөлөөлөгдөж байна гэх зэргээр нэлээн л давуу талтай, давуу талууд үүсгэж байж л энэ төсөл хэрэгжиж байгаа. Нөгөө талд нь Монголын ААН-үүд бас давгүй хуримтлалтай ажил хийж чаддаг болчихсон. Одоо сая 2025 оны 1 сарын статистикаар гэхэд Монголчууд Монголын банканд 22 их наяд төгрөгийн хадгаламж байгаа. Дотоодын банканд. Тэгээд ер нь энэ дотоодын ААН-үүдээ дэмжих энэ бүтээн байгуулалтад оролцуулах ер нь дотоодын ААН-дээ ашиг, үр ашгийг нь хүртээдэг байх энэ талд ер нь Эдийн засаг хөгжлийн яам одоо яг энэ 2026 онд бодож байгаа төлөвлөж байгаа юм байгаа юу? Яах вэ сая Төсвийн тухай хуулийг дагаад Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нааштай ийм заалтууд орж ирсэн. Гэхдээ ний нуугүй хэлэхэд зарагдахгүй орон сууц барьж байгаа барилгын компаниуд нэг 40 сургуулийг бариадах гэвэл дор нь л барьчихна л даа. Зүгээр буцаагаад улс ямар санхүүжилт, ямар үр өгөөжтэй, ямар хугацаанд төлөх вэ энэ тэр гэдгээ л тодорхой болгоод хувийн хэвшилдээ ч ашигтай улс ч гэсэн төсөв дээр ачаалал үүрэхгүй ийм зохицуулалт хийвэл энэ асуудлуудаа шийдээд яваад байж болно гэж харж байгаа.

Тийм учраас одоо ер нь энэ төр хувийн хэвшлийн түншлэл дээр бас ер нь ямар өөрчлөлт энэ яг энэ 2026 онд гарах вэ? Энэ талаар нэг Эдийн засаг, хөгжлийн сайд нэг хариулт хэлээч гэж ингэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энхбаяр сайд. Дараа нь шаардлагатай бол Сангийн яам.

Ж.Энхбаяр: Орон нутгийн нийслэлийн шаардлагатай энэ сургууль цэцэрлэг барих асуудал. Энэ эх үүсвэр нь шийдэгдсэн үед хувийн хэвшлээр төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байж болно. Эсвэл томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа орон сууцын хороолол барьж байгаа ААН-үүд гэрээлээд бариулж болно. Гол нь тэр асуудлаа шийдэх эх үүсвэр нь бий болж байгаа юм. Энэ бол нэлээдгүй хэмжээнд буцалтгүй тусламжтай нэн хөнгөлөлттэй ангилалд орж байгаа урт хугацааны, ийм санхүүжилт. Энэ санхүүжилтийн гол зорилго бол олон жил яригдсан эрүүл мэндийн салбар. Аймгийн төвүүд дэх нэгдсэн эмнэлгүүдийг иж бүрэн шинэчлэх, өргөтгөх, яаралтай тусламж үйлчилгээг тэр чадавхыг бий болгох том ажил байна. Аврах онцгой байдлын байгууллагын олон жил ярьсан асуудал энэ хүрээнд шийдэгдэж байгаа. Тэгээд төсөлтэй холбоотой нарийн асуудлыг ажлын хэсэг Сангийн яамныхан хариулах байх гэж. 6 номер хариулъя гэж байна.

Г.Тэмүүлэн: 6 номер нэмж хариулъя. Албан тушаал.

Б.Хулан: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн дэд сайд Хулан. Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Хоёр тал Засгийн газар хоорондын 2 талт хэлэлцээрийн тухайд бол хэлэлцээ хийсэн тал өөрийнхөө дотоодын ААН-үүдийг илүү түлхэх ийм нөхцөлүүд орж ирдэг. АХБ-ны тухайд олон талт хамтын ажиллагааны ийм Хөгжлийн банк учраас дотоодын ААН-ийг оролцохыг хааж хориглосон зүйл байхгүй. Шаардлага шалгуур хангаж байгаа дотоодын ААН-үүд бүгдээрээ оролцоод явах боломжтой. Худалдан авах ажиллагааны тухайд бол ОУБ-ынх нь худалдан авах ажиллагааны дүрэм журмаар давхар зохицуулагддаг.

Тэгэхээр миний санаж байгаагаар зөв бол сая доллароос дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаа нь олон улсын тендер зарлагддаг. Түүнээс дооших нь болохоороо Худалдан авах тухай хуулиараа ингээд зохицуулагдаад явдаг аа.

Тэгэхээр Хосбаяр гишүүний асуултад хариулахад дотоодын ААН-ийг хааж хориглосон зүйл байхгүй. Санхүүжилтийн өртөг дээр нэмэлт.

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулъя 6 номер.

Б.Хулан: 2 хэлэлцээ дээр хоёулан дээр нь хөндөгдсөн Хосбаяр гишүүний асуултад хариулахыг хичээе ээ. Санхүүжилтийн өртгийн тухай мөн эргэн төлөлтийн тухай асууж байна. Түрүүн хэлсэнчлэн бас өмнөх зүйл дээр энэ дээр болохоороо нэн хөнгөлөлттэй зээл нь 2 хувийн хүүтэй. Энгийн зээл нь болохоороо софер дээр нэмэх нь 0.6 гэсэн ийм эх үүсвэрийн өртөгтэй орж ирж байгаа. Энэ бол бас олон энэ төрлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон давуу талыг бий болгож байгаа. Өнөөдрийн байдлаар софер хүү маань бол 3.64 хавьцаа байна. Өнгөрсөн жилүүдэд олон улс геополитик, цар тахал гээд энэ нийлүүлэлтийн гинжин хэлхээний таслал, инфляц гээд олон шалтгааны улмаас энэ хүү өндөр болж ирээд түүхэн дээд хэмжээндээ буюу 5 нэлээн гарсан. Ойрын жилүүдэд энэ софер хүү бас ингэж буурах үзүүлэлттэй байгаа. Эх үүсвэрийг бид нар доллароор аваад төгрөг рүү хөрвүүлэхэд дунджаар 7-8 хувийн зардал гардаг.

Тэгэхээр Монголбанкны бодлогын хүү 12 хувь, инфляц 8.2 гэж үзэх юм бол байж болох хамгийн.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж тайлбар хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр нөгөө авч байгаа зээлийг үр өгөөжтэй байлгах зорилгоор бид энэ 17 аймгийн нэгдсэн эмнэлэг дээр том шинэчлэл хийнэ. Яагаад 21 биш вэ гэхээр 4 аймаг нь жишээлбэл Увс, Ховдод бол энэ ADB-ийн төслөөр өргөтгөлийн ажил нэг ёсондоо энэ өмнөх туршилтын барилгууд нь хийгдээд дуусчихсан. Ойролцоогоор 7-10 сая долларт нэг аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөл хагалгааны хэсэгтээ эрчимт эмчилгээтэй оношилгоо, яаралтай тусламжийн тасгуудыг хийхэд ийм зардал гарч байгаа. Үлдсэн 4 аймагт нь жишээлбэл Булганд бол улсын төсвөөр барьж эхэлчихсэн.

Дарханд болохоороо Европын сэргээн босголтын банкаа бариад явж байгаа. ингээд 4 газар нь угаасаа хийчихсэн учраас бид төсвийг давхцуулахгүйгээр нөхцөл байдлын үнэлгээ хийгээд яг шаардлагатай газрууд нь хэрэгтэй зүйлийг нь хийж өгнө.

Дээрээс нь 130 түрүүн хэллээ. Интернэтэд суурилагдсан 130.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмээд тодруулж асууя.

Г.Хосбаяр: Сая Энхбаяр сайд миний асуултыг нэг их анхаараагүй юм шиг байна. Би зүгээр товчхондоо ингэж л асуугаад байгаа юм. Одоо ингээд хувийн хэвшилд боломж байгаа. Тэгэхээр ер нь нөгөө концесс зарлах уу? Ирэх жилүүдэд. Энэ Монголын дотоодын ААН-үүд бас хөрөнгө санхүүгийн боломжтой ААН-үүд байна. Тэгэхээр улсад ч ашигтай, хувийн хэвшилдээ ч ашигтай тэр хүүг нь багаар тооцоод тохиролцоод ингээд ийм концессын ажил бүтээн байгуулалт хийгдэх үү гэж л товчхондоо асуугаад байгаа юм.

Дараагийнхыг нь би онцгой байдлын газраас асууя.

Саяхан Өвөрхангай аймгийн онцгой байдлын газарт очиж ажил байдалтай нь танилцаж ажилласан. Тэгэхэд яах вэ тэр гал унтраах машин ч гэдэг юм уу ямар ч байсан 10 давхар барилгад хүрэх гал унтраах машин тоног төхөөрөмжтэй болчихсон гээд л Францын зээлээр гээд нэлээн өндөр үнэтэй тоног төхөөрөмжүүд байна лээ. Түүнээс гадна яг цас зудтай нөхцөлд хөдөө явдаг машин нь болохоор нөгөө Оросын 31 ч гэдэг юм уу бензин тос их зарцуулдаг.

Г.Тэмүүлэн: Тодруулж асууя Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Яг цас зуд ч гэдэг юм уу ой хээрийн түймэр ч гэдэг юм уу давагдашгүй хүчин зүйл байгалийн гамшиг үүссэн нөхцөлд тэр хол зам туулах тийм машин тоног төхөөрөмж, тэр тал дээр нь ер нь анхаарч хангалтыг нь сайн хийж өгөх үү? Энэ яг одоо авч байгаа зээл тусламждаа түүнийг багтаах ийм боломж бололцоо байгаа юу?

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд, дараа нь Ариунбуян дарга.

Ж.Энхбаяр: Концессын асуудлыг явуулна аа. Гэхдээ зарчим ингэж өөрчлөгдөж байгаа. Хуучин барих, ашиглах, шилжүүлэх гээд. Эсвэл бариад шилжүүлэх хэлбэрт явж байсан бол одоо бол барих ашиглах гэдэг.

Монголд дэд бүтцийн болон эрчим хүчний томоохон хөтөлбөрт өөрийн санхүүжилтээ оруулаад бариад, өөрөө ашиглаад, өөрөө тэндээсээ төлбөрөө ашгаа олоод энэ нь ийм санал өгч байгаа ААН-үүдэд концессыг явуулаад нээлттэй явна. Жишээлбэл хамгийн бодитой санал гэхэд энэ Чойр Замын-Үүдийн 4 эгнээ хурдны энэ зам. Мөн дараагийн чиглэлд Дархан, Сэлэнгэ гэх мэт юм уу ер нь эдийн засгийн өгөөжтэй тооцоо бизнес болох бололцоотой гэсэн энэ зам, дэд бүтцийн эрчим хүчний дамжуулах шугам байна. Эрчим хүчний станцууд байна. Энэ хувийн хэвшил өөрөө технологио нэвтрүүлээд хөрөнгөө гаргаад хийнэ гэвэл концессуудын бодлогыг маш сайн ингээд дэмжиж хөшүүрэгдэж явуулна.

Г.Тэмүүлэн: Ариунбуян дарга 4 номер.

Г.Ариунбуян: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ чухал асуудал хөндөж байна аа. Цас зудтай үед онцгой байдлын байгууллагаас ажиллаж байгаа автомашины хүрэлцээ хангамж их сул байдаг. Тийм учраас өнгөрсөн 2023 оны зудны үеэр бид нар зэвсэгт хүчнээс нэмэлтээр Зил-131 маркийн автомашинд дэмжлэг авч айл өрхөд төрийн үйлчилгээ хүргэх, нэмэлт тэжээл хүнсний тэжээл хоол хүнс хүргэх ажлыг зохион байгуулсан. Энэ АХБ-ны төсөл хэрэгжих юм бол яг одоо таны яриад байгаа тэр ой хээрийн түймэртэй тэмцэх, цас зудтай тэмцэх, үер устай тэмцэх энэ чиглэлийн автомашин тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэнэ.

Өнөөдрийн байдлаар тухайлбал ой хээрийн түймэр унтраах автомашины хангамж улсын хэмжээнд 10 хувьтай. Энэ төсөл хэрэгжвэл 100 хувийн хангалттай болно. Мөн цас зуд энэ үер усанд ажиллах, эрэн хайх, аврах ажиллагааны тусгай зориулалтын автомашин 33 хувьтай байгаа. Мөн энэ төсөл хэрэгжсэнээр 80 хувийн ийм хангалттай болж нэмэгдэх юм байгаа юм аа. Үндсэндээ чадавх сайжирна аа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай төслийг 100 хувь дэмжиж байгаа юм аа. Яагаад гэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн бүх заалт бүрэн хангасан байна, заалтуудыг.

6 дугаар зүйл төсвийн тусгай шаардлага бүгдийг хангасан байна аа. Тэгэхээр энэ цаг үеэ олсон ийм төсөл, ийм зээл гэж харж байна аа. Надад 2 асуулт байна. Эрүүл мэндийн сайд болон Боловсролын сайдаас.

Нэгдүгээрт энэ төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ер нь Баян-Өлгий аймагт хэрэгжих төслүүд байгаа юу. Эрүүл мэндийн сайдаас. Ялангуяа энэ орон нутгийн эрүүл мэндийн барилга байгууламжийг барих нас баралт ихтэй болохоороо орон нутаг руу чиглэсэн байна шүү дээ. Тэгэхээр Баян-Өлгий аймагт төсөл хөтөлбөр байна уу? Боловсролын салбараас бас асуусан.

Баян-Өлгий аймагт одоо жагсаалтыг нь харахад нэг ч төсөл хэрэгжээгүй байсан хэрэг. Жагсаалт нь байхгүй байсан. Тэгэхээр энэ жагсаалтыг ер нь ямар шалгуураар гаргасан бэ? Энэ шалгуурыг нь хангаж энэ жагсаалтад орох сургууль бариулах боломж байна уу? Энэ тал дээр та асуулт асуух гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Чинбүрэн сайд, дараа нь Боловсролын яам.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр энэ ADB-ийн төслийн хүрээнд энэ түргэн тусламжийг сайжруулах энэ гол ажил ерөөсөө л 21 аймагт жигд хүртэнэ. Ялангуяа Баян-Өлгий аймаг алслагдсан, хамгийн их алслагдсан. Дээр нь бартаа зам ихтэй сумдууд аймгуудтай холбогдох энэ нөхцөл байдал тийм амар биш байдаг. Тэр утгаараа бол нэгд эмнэлгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөл хийгдэнэ. Тэр өргөтгөл дотор хагалгаа хийдэг харваад шигдээс болоод ирсэн хүний ангиографин катлаб гэж бид мэргэжлийн үгээр хэлээд байгаа. Тийм судасны бөглөрсөн судсыг тэлж онгойлгодог, эмчилгээний том төв нь нээгдэнэ.

Дээрээс нь эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжүүд бүх аймгуудад сууна. Дээрээс нь сургалт хийгдэнэ. Хүний нөөцийг бэлтгэж өгнө.

Дээрээс нь явуулын эмнэлэг буюу 130 энд орон нутагт туулах чадвар сайтай. Түргэн тусламжийн машин. Бид энийг машин гэхгүй байгаа юм. Бүр явуулын эмнэлэг гэж нэрлээд байгаа. Тэр дотроо дээд хэмжээний амь насаа аврах бүх төрлийн тусламж үйлчилгээ яаралтай тусламж үзүүлдэг тоног төхөөрөмжтэй хэрэгсэлтэй. Дээрээс нь Старлинкийн интернэт холбоотой. Холбоогоороо дамжуулаад веб зөвлөгөө Улаанбаатар хотын колл центрээсээ байнгын зөвлөгөө авч дуудлага дээр очно. Хүнээ тээвэрлэх явцдаа эмчилгээгээ хийгээд явна. Эмнэлэгтээ очиход ямар хүн ирж байгаа вэ гэдгийг эмнэлэг нь мэдээд бэлтгэл ажлаа хангачихсан. Ингээд бид яаралтай тусламжийг жинхэнэ нэг өндөр түвшинд Монгол улс даяараа гаргаад өндөр хөгжилтэй орнууд чинь зүрхний шигдээсээр хүн нас барахаа больчихоод байгаа шүү дээ. Бид ийм хэмжээнд бүх аймгуудад ижил хэмжээнд хөгжүүлэх энэ бодлого хэрэгжих юм аа.

Ер нь бол энэ 230 гаруй сая доллароор энэ Монгол Улсын яаралтай тусламжийг сайжруулах бол бид бага зардлаар харин их ажил хийх гэж байгаа гэж дотроо их баяртай байгаа.

Г.Тэмүүлэн: Боловсролын яам 8 номер.

Х.Батжаргал: Боловсролын яамнаас Батжаргал гишүүний асуултад хариулъя аа. Ер нь бол урьдчилсан судалгаа тооцоолол хийгээд 2030 он хүртэл 108 сургууль, 95 цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага байгаа. Үүнээс нэн тэргүүнд тулгамдсан ялангуяа Улаанбаатар нийслэл хот хүн амын нягтаршил төвлөрсөн ийм газрууддаа 3 ээлжийн эрсдэлээс сэргийлэх хамгийн тулгамдсан төслүүдээ эрэмбэлээд орон нутагт хүүхдийн аюулгүй байдал хангагдахад эрсдэл үүссэн. Мэргэжлийн дүгнэлт гараад акт үйлдэгдчихсэн. Ийм хүнд нөхцөл байдалтай сургуулиуд цэцэрлэгүүдийг нэн тэргүүнд шийдвэрлээ гэсэн ийм зарчим бариад тэгээд мөн дээрээс нь АХБ-ны зээлдүүлэгч талын шалгуур шаардлага, нийгэм жендер, байгаль орчин, дэд бүтэц энэ олон шаардлагууд дээр үндэслээд ингээд явж байгаа.

Баян-Өлгийн аймгийн тухайд бол яг одоогоор 3 ээлжийн болон Улаанбаатар шиг ингээд бусад орон нутгуудтайгаа адилхан стандартын түвшинд бүлэг дүүргэлт хэвийн явагдаж байгаа. Акт үйлдэгдээд аюулгүй байдалд эрсдэлд учирсан ийм сургууль байхгүй. Харин нэг цэцэрлэгийн 100 хүүхэдтэй цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага бол тулгамдаж байна гэсэн ийм дүгнэлтийн дагуу энэ танилцуулга төлөвлөгөөнд тусгаад цуцлагдаад явж байгаа гэдгийг хэлэх байна аа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Боловсролын яамныхан судалгаа буруу хийсэн байна аа. Баян-Өлгий аймагт хүн амын тоо жилээс жилд өсөж байгаа. Нэг ангидаа 40-өөс дээш хүүхэд хичээллэж байгаа. Наад судалгааг чинь ямар компани хийсэн бэ? Та тэрнийг тодорхой хэлэх хэрэгтэй. Би тэр жагсаалтыг асуусан чинь танай аймагт зураг төсөв нь гараагүй болохоор бид ганцхан төслийг л энэ жагсаасан гээд хэлсэн. Тэгж худлаа ярьж болохгүй ээ. Тэгэхээр та тэр судалгаа хийсэн компанитайгаа мэдээллийг надад хэлж өгмөөр байна аа. Чинбүрэн сайдаа манайд шинэ эмнэлэг, нэгдсэн эмнэлэг баригдсан шүү дээ. Тэгээд нэгдсэн эмнэлгийн өргөтгөл гээд та хэллээ. Сая тэгэхээр энэ эрүүл мэндийн багуудын төв их хэцүү болчихоод байгаа шүү дээ. Багтдаггүй, хүн амын тоо ихэссэнээс болоод. Тэгэхээр энэ багуудын ЭМТ-ийг.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Баян-Өлгийн нэгдсэн эмнэлгийн барилга өчигдөр хүлээж авах комисс ажилласан байх ёстой. Тэрний дүгнэлтийг би харин сонсоогүй байна. Дээрээс нь доторх тавих тоног төхөөрөмж тэр ашиглалтад оруулах юу энэ 2026 оны төсөвт байгаа тэрийг хийнэ. Гэхдээ бидэнд нөгөө давхацсан ажлууд хийхгүйн тулд өргөтгөл нөгөө дутуу эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн л зүйлүүд дээр нь нэмэлтээр дутуу зүйлийг нь л хийж өгөх юм.

Тэгэхээр энэ нөхцөл байдлын дүгнэлт гаргасан зөвлөх баг ажиллачихсан бүх аймгуудаар яваад ажиллачихсан. Юу дутуу байгаа, ямар тоног төхөөрөмж хэрэгтэй байгаа, ямар боловсон хүчин дутагдалтай вэ энэ тэр гэдгийг бүгдийг нь гаргана. Харин сумдууд болон багуудад нөхцөл байдал тийм амаргүй байгаа мэдэж байгаа.

Тухайлах юм бол нөгөө Хотгор шанагад байдаг багийн эмнэлгийн асуудал. Тэн дээр бид очиж ажиллаж барилгын компанийнх нь ажлыг нэлээн хурдлуулж овоо гайгүй гүйцэтгэл болж байгаа. Гайгүй болж байгаа.

Г.Тэмүүлэн: Боловсролын яам. 8 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж тодруулъя аа. Боловсролын Батжаргал. Тэгэхээр энэ судалгаа тооцооллыг хийхэд улсын төсвийн боловсруулалт хийгдэж байх явцад Боловсролын яаман дээрх рийл таймаар яг сургуулийн суралцагчид суралцаж байгаа тоог шууд татаад тухайн үеийн Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос Засгийн газраас холбогдох яамдууд ингээд нэгдсэн ажлын хэсэг гараад бүх тоо судалгаагаа нэгтгээд ингэж гаргасан тоо байгаа. Аливаа нэгэн тийм хувийн хэвшлийн тоо судалгаанд тулгуурлаагүй.

Нөгөөтээгүүр ээлжийн коэффициентыг эрэмбийн чухал зүйл гэж авч үзэж байгаа. Ээлжийн коэффициент гэдэг маань 2-оос дээш гарах юм бол 3 ээлж рүү орох эрсдэл тухайлах юм бол Улаанбаатар хотод бид нар 50-аас 70 хувьтай ингэж ярьдаг шүү дээ.

Тэгээд тийм хэмжээнд орон нутагт хараахан очоогүй байгаа. Тийм учраас бид нар ээлжийн коэффициентыг нэн тэргүүний эрэмбэд оруулж байгаа гэж хэлэх байна аа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн, асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Ерөнхийдөө төсөл хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд 1 асуултыг тодруулаад асуучихъя, Боловсролын яамнаас. Энэ сайд нь хаачсан юм бэ? Чөлөөлөгдөж барьчхаагүй биз дээ ойрд харагдахгүй байх юм. Улаанбаатар хотод дүүргүүдэд сургууль цэцэрлэг хуваарилсан байна лээ. Энд жагсаалт нь алга байна. Чингэлтэй дүүрэг өмнө нь харагдахгүй байгаад байсан санагдаад байх юм. Тэгээд дүүргийн удирдлагууд мэдээлэл судалгаагаа өгсөн гэж ойлгосон яаманд. Чингэлтэй дүүрэг сүүлийн жилүүдэд барилгажих гэж нэлээн хурдацтай хийгдэж байна. Тэрийгээ дагаад хүн амын нягтрал нэмэгдэж байна. Дүүргийн удирдлагууд чинь өөрсдөө дүүргийнхээ төр захиргааны байрыг төвөөс гэр хороолол руу шилжүүлэх ажлыг эхлүүлчихсэн ажиллаж байна. Гэр хорооллынхоо дунд онцгой байдлын анги байгууллаа. Мөн гэр хорооллынхоо голд шинэ эмнэлэг барих гээд ажиллаж байна. Энэ дээр Боловсролын яам маань яаж дэмжлэг үзүүлж байна тэр хэрэгцээтэй байгаа хэд хэдэн судалгаанууд бий. Буулгаж барих, сургууль цэцэрлэгийн асуудал байна. Засвар хийх, сайжруулах, өргөтгөл хийх, сургууль цэцэрлэгийн асуудал байна. Шинээр барих шаардлагатай судалгаанууд ч байна. Эд нар дээр түшиглээд та нар ер нь наад жагссан жагсаалтад чинь Чингэлтэй дүүрэг гэдэг нэр байна уу байхгүй юу. Энийг нэг тодорхой хэлээдхээч. Тэгээд би нэмж асууя.

Г.Тэмүүлэн: Батжаргал дарга хариулъя. Боловсролын яамнаас 8 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Батжаргал боловсролын яам. Тэгэхээр өнгөрсөн удаа Улсын Их Хурал дээр тус зээлийн ерөнхий хэлэлцээр хэлэлцүүлгийн явцад судалгааны дүнг танилцуулж байсан. Тухайн судалгааны явцад бас орон нутгаас яг гишүүний хэлдгээр орон нутгийн идэвхтэй хүчин

чармайлтын дүнд боловсролын салбарынхаа асуудлуудыг нэлээн сайн шийдэгдсэн нягтаршлаа дагаад барилгажилт үнэхээр сайн явагдсан. Энэ судалгааны дүн гарсан. Гэсэн хэдий ч гэсэн гишүүний тавьсан саналын дагуу бид нар нэмэлт судалгаа хийгээд дүүрэг орон нутаг ЗДТГ, Нийслэлийн боловсролын газартай ажиллаад хэд хэдэн хувилбарт байршлыг тогтоогоод Азийн хөгжлийн банктайгаа хамтраад ажилласан. Тухайлах юм бол 5 дугаар сургууль, 17 дугаар сургууль гэсэн байршил дээр шинээр барих газар байхгүй учраас нураагаад шинээр барих энэ хувилбар нэлээн хүндрэлтэй. Тухайн хүүхдүүдэд сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх ийм эрсдэл байгаа.

Нөгөөтээгүүр манай дүүрэг нийслэлээс ЧД-ийн 9 дүгээр хороонд боломжит газрыг чөлөөлөөд бэлэн байдлыг хангасан байгаа. Тэгэхээр Азийн хөгжлийн банк бидэнд талууд энэ судалгаандаа эрэмбэлсэн энэ жагсаалт судалгаандаа оруулаад явж байгаа. ЧД-ийн 9 дүгээр хороон дээр газар чөлөөлөлтийн ажил ер нь бэлэн байдал хангагдаж байгаа гэж үзсэн.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн, нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Яг тэр листэнд байна уу байхгүй юу? Тэрийг нэг тодорхой хэлэхгүй бол сая нэлээн ерөнхий ярьчихлаа шүү. Тэгээд энэ танай сайд ер нь байгаа юу? Энэ чинь Батжаргал маань сайдын ажил хийгээд байна уу? Тэр хэн билээ? нэрийг нь мартчихлаа шүү дээ. Энэ боловсролд Монгол Улс чинь боловсролын салбартаа сайд байна уу байхгүй юу? Энийг зарлан мэдээлдэг юм уу яадаг юм.

Г.Тэмүүлэн: 8 номер Боловсролын яам.

Х.Батжаргал: Энд жагсаалтад байгаа судалгаа бүгд судалгааны түвшинд бүх шалгуур шаардлагыг хангаад явж байгаа. Тэгэхээр 9 дүгээр хороонд ЧД-ийн 9 дүгээр хороонд энэ шинээр орсон байршил жагсаалтад ороод явж байгаа гэж ойлгож болно оо. Наранбаяр сайдын тухайд эрүүл мэндийн чөлөөтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Энэ авч байгаа зээл энэ төлж байгаа татвар төлөгчдийн мөнгө төгрөгийг үр дүнтэй зарцуулмаар байгаа юм аа. Энийг үр дүнтэй зарцуулахын тулд эхлээд тэр нэг гоождог тэр авлига, энэ хэнэггүй хандлага энэ ажилдаа хандах энэ юмнуудыг эхлээд нэг янзалчихаад дараа нь тэр хөрөнгө оруулалт энэ юмнуудаа шийдмээр байгаа юм л даа. Тэгээд уул нь авсаархан цомхон энэ чинь техник технологи энэ тэр чинь шал өөр болчихоод байна шүү дээ. Тэгээд л нөгөө л нэг 10, 20 жилийн өмнөх ийм арга хандлагаараа л хандаж байна. Тэгээд энэ даатгал гээд л бүх юм л ажилладаг шүү дээ. Хар л даа. Тэр байшин шатлаа энэ тэр гээд л яасан. Тэгээд л дараа нь татвар төлөгчдийн мөнгөөр л босгох гэж байгаа юм шиг байгаа юм. Авлига нэгд явчихсан.

Улаанбаатар хотод нөгөө авлига хороолол нь сүндэрлээд л байдаг. Гэр хороолол зохион байгуулалт сайн хийчихвэл тэр түргэн тусламжийн эмнэлэг эмч нар очих боломж бололцоо хаягжуулах энэ тэр гээд л. Ийм юмыг чинь ямар ч мөнгө шаардахгүйгээр хийчихмээр байгаа байхгүй юу. Энийгээ хийхгүй өчнөөн олон жил явлаа. Яваад л байх юм. Тэгээд л орон тоогоо нэмээд л байна. Их л олон яам их л олон сайд нар. Тэгээд боловсролын салбар өнөөдөр дампуурчихсан. Тэр писагийн шалгалтаар ямар үр дүн үзүүлээ.

Уншаад юмаа ойлгохгүй хүүхдүүд байна гэж байгаа шүү дээ. Тэр тоо, физик, математикаар байхгүй бүгд унаж байна. Тэгээд боловсролын салбарын ямар яам ямар намд хариуцуулчихаад байгаа юм. Нэг жагсаалтын хэдэн гишүүдтэй ганцхан ард түмний санал авсан гишүүнтэй. Тэр хүн сайн багш байж болно. Сайн хувийн сургуулийн захирал байж болно. Тэгээд боловсролын салбар чинь өнөөдөр ямар болчихоод байна. Та хэд 68 гишүүнтэй болохоос биш тэр нам олонх биш шүү дээ. Тэгээд хариуцлагаа тийш нь чихчихдэг ийм байна шүү. Манай Чинбүрэн сайд сайн эмч, сайн мэс засалч. Үгүй энэ хүнээ тээр юмыг нь л хийлгэмээр байгаа байхгүй юу. Гэтэл тэгээд л буруу зүйл рүү нь татаад л мэдэхгүй сайн зохион байгуулагч сайн сайд байхыг би тэрийг нь мэдэхгүй байна. Тэр ажлыг нь харж байж л хэлэх байх даа. Тэгээд юу билээ хэдэн зах шатаад байна гэсэн. Тэр Хөвсгөлийн захыг ч, Увсын захыг ч бас л татвар төлөгчдийн мөнгөөр хаах юм уу? Тэр зээл тусламжаар хаах юм уу тийм л яриа болоод байх шиг байна. Манай Баянхонгорт яг адилхан зах байгаа байхгүй юу. Хувийн хэвшлийнхэн л хийдэг шүү дээ. Тэгээд шатчихвал тэр даатгал юмаараа л хариуцдаг.

Нэг иймэрхүү системүүдийг ажиллуулмаар байна аа. Энэ талаар та нар ямар бодолтой байдаг юм? Тэгээд л нэг зээл авна, татвар төлөгчдийн мөнгийг ингэж тийш нь зарцуулна гээд л ингээд л сонин сонин юм яриад ороод ирдэг. Наад ажлаа үр дүнтэй техник технологи ашиглах, төсвийг хэмнэлттэй зарцуулах, төрийг авсаархан байлгах ийм зүйлүүд ерөөсөө яригдахгүй байна шүү дээ. Энийгээ та нар хэзээ ярьдаг болох юм бэ? Иймэрхүү байдлаар байх юм бол энэ ажил төрөл сайжрахгүй ээ.

Бид нар ярьдаг юмаа яриад л гоё сайхан ингэж байшин сав барьж байна ийм сайхан болно оо л гээд байдаг, үр дүн байхгүй л байна шүү дээ. Тэгээд төрөлтийг хар.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн.

Д.Ганбат: Жилд 100 мянган төрөлттэй байсан байхгүй юу. Монгол Улс одоо 00 мянган хүнээр нэмэгдээд байна гэсэн үг. Гэтэл буурчихсан 50 хэдэн мянга. Хоёр дахин буурч байгаа байхгүй юу. Энэ та нар ямар бодлого явуулаад ямар үр дүнд хүрээд байна аа. Тэгээд сая тэр нас далан хэд хүрч л байна гэнэ л дээ. Тэрбум 500 саяын хүнтэй манай хажуу талын Хятад улс чинь наян хэд шүү дээ. 3 сая 500 мянган хүнтэй энэ эмнэлэг эмчилгээний үйлчилгээ ямар байна вэ гэдэг нь энүүгээр илэрч байгаа байхгүй юу. Угаасаа л дэлхий нийт юм хөгжөөд л нэг ийм болж байгаагаас биш нэг их сайн ажиллаад бид нар ийм болгоод байна гэсэн юм байхгүй. Уул нь 3 сая 500 мянган хүнтэй. Өнөөдөр бид нар чинь 90 нас хүрч байх ёстой байхгүй юу. Дундаж наслалт. Хэрэв сайн байсан бол. Ийм ийм юм байна шүү нөхдүүд ээ. Энийгээ юу гэж бодож байгаа юм бэ та.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуулт, санал дээр тайлбар мэдээлэл. Энхбаяр сайд, Чинбүрэн сайд. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Ганбат гишүүний шүүмжлэлтэй хандаж байгаа юмыг санал нэг байгаа. Ялангуяа сая тэр энэ зах шатаж байна гээд л юм яриад нөгөө. Өмнөх нөгөө балаг гээд л гараад байгаа юм. Их Хурлын гишүүд санаачлаад орон нутагтаа санал авах гээд ингээд байшин барьж зах барьчихдаг. Тэндээ өмч нь улсын төсвийн өмч байдаг. Тэгээд тэрийгээ орон нутгийн өмчид хариуцуулаад үлдээчихдэг. Ингээд

орон нутгийн Засаг даргын Тамгын газар тэр захыг менежмент хийдэг үүрэгтэй. Тэгээд саяын энэ Хөвсгөл, Увс гээд энэ захуудын асуудал. Ингээд түүх яривал би тэр үед гишүүн байсан хүнийг мэдэж байна л даа. Алтанхуяг Ерөнхий сайд 50 тэрбум төгрөгийн хүрээнд 8 газар зах барьсан юм байна лээ. Ерөнхий сайд байхдаа. Тэрнээс 2 нь шатчихаж байгаа. Ахиад 6 цаана байна. Сая Засгийн газар дээр энэ асуудлыг ярилаа. Иргэдийн хохирлын асуудал байна ер нь яах вэ гээд. Ер нь энийгээ яаралтай хувьчлах, олон нийтийн болгох. Ер нь төсвийн хөрөнгө оруулалтаар ахиж ийм хувийн хэвшлийн хийх бололцоотой орон зайг дээд зэргээр хязгаарлана. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль гээд та бид сая баталсан. Тэрүүгээр 5 жилийн хөтөлбөр орсон. Тэнд зөвхөн эх үүсвэртэй, эдийн засгийн үр өгөөжтэй, ТЭЗҮ нь гарчихсан ийм төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж хэрэгжүүлнэ гээд бүр хууль болгочихсон.

Энэ хууль бол төсвийг нэлээн сахилгатай, хариуцлагатай, дур зоргын хөндлөнгийн санал ордог зүйлүүд нэлээн сайн хязгаарлагдаж байгаа. Тэгээд бид чинь ингээд парламент чинь ингээд сайжраад бодлого нь тодорхой болоод ингээд явж байна шүү дээ. Тэгэхээр энэ хаврын төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оны хөгжүүлэх үндсэн нэг жилийн хөгжлийн бодлого эд нар нэлээн чамбайрсан дандаа эх үүсвэртэй, ТЭЗҮ-тэй ингэж орж ирнэ. Тэгээд хаана хаанаа л хичээмээр байгаа юм. Нэг иймэрхүү зүйлүүд л яваад байгаа юм. Та эрүүл мэнд дээрээ ярь даа.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж тайлбар өгье.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн салбар эрвийх дэрвийхээрээ хичээгээд ажиллаад. бидэнд тогтолцооны дутуу байгаа зүйлүүд байна. Ялангуяа саяын хэлдэг аварч болох нас баралт. Өндөр хөгжилтэй орнуудад зүрхний шигдээсээр нас барахаа больчихоод байгаа юм. Тийм тэгэхээр Монгол Улс ч гэсэн энэ тогтолцоо руугаа хаана амьдарч байгаагаасаа үл хамааран эрүүл байх амь аврагддаг байх өөрөө их чухал. Тэгэхээр энэ тогтолцоог энэ санхүүжилтээр хийх гэж байна аа. Таны хэлж байгаатай санал нэг. Ер нь бид энэ шударга бус байдал, энэ даатгалын цоорхой уутыг битүүлж авах ажил бол энэ 2025 оны 6 сараас хойш нэлээдгүй хийлээ. Үүний үр дүнд бид жилд 470 тэрбум төгрөгийн өртэй гарах байсныг 190 рүү буулгаж чадлаа. Ингээд 2026 онд илүү тогтолцоог илүү нээлттэй болгох, шударга байлгах, хулгай хийдэг байх боломжийг хаах ийм тогтолцоонуудад нэлээдгүй ажил хийгдэнэ ээ. Бид амлалт ярихгүй, үр дүн ярина 2026 онд. Аварсан хүний тоо болгон чухал.

Дээрээс нь хүүхдийн төрөлтийг та чухал сэдэв.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд гүйцээж хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр Монгол Улсын хамгийн өндөр хэмжээнд төрж байсан жилийн тоо бол нэг 90 мянгад нар хүрч байсан. Одоо бол яг таны хэлж байгаа үнэн 55-аас нэг 60 мянга орчим л байна шүү дээ. Одоо өнгөрсөн 2024 оны тоогоор 1 56200 гаруй хүүхэд төрсөн амьд төрөлт. Тэгэхээр энэ бол нөгөө хүн амын өсөлт буурах ийм хандлага. Энэ хандлага бол эдийн засаг хөгжих тусам улс орнуудын төрөлтийн тоо буурдаг. Яг л энэ механизмтай адилхан жишээ Монгол Улсад байгаад байгаа.

Тийм учраас бид хүн амаа өсгөх энэ бодлого дээрээ дахиад Их Хурлын гишүүд бид бүгдээрээ энэ дээрээ анзаарч анхаарч цаашид ямар бодлогоор бид хүн

амаа өсгөх вэ? Бид чинь 2050 он гэхэд 5 сая иргэдтэй болох гээд байгаа шүү дээ 50 онд. Тэгэхээр энд хүрэхийн тулд энэ тоо маань энэ эрчээрээ явах юм бол буурчих хүрэхгүй байх ийм магадлалтай байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтад бэлтгэцгээе. Гишүүд хуруугаа хийгээрэй. Гишүүдийг дуудаарай. Очирбат гишүүн, Жаргалан, Болормаа гишүүн, мөн дээрээс нь Бат-Амгалан гишүүн, сая Засгийн газрын зүгээс саяын гишүүдийн хэлсэн саналуудаар нэлээн анхаарч ажиллаарай. Эрүүл мэнд, боловсролын салбар дээр голчилж анхаарч саналууд хэлж байна шүү. Боловсрол, эрүүл мэндийн салбарын энэ тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийн асуудлуудыг нэлээн голлож ярьж байна. Энэ дээр бид нэлээн анхаарах зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ удаагийн зээлийн хэлэлцээр хөтөлбөртэй холбогдуулаад үндсэндээ бараг 20, 30 хувь нь л боловсролын салбар дээр байгаа.

Тэгэхээр энэ дээр болж өгвөл өмнөх нөгөө нэг намар орж ирж байхад манай гишүүд хэлж байсан зүйл нь үндсэндээ энэ боловсролын салбар дээр хийгдэх хөрөнгө оруулалтын асуудлыг бас голлож анхаарах, сургууль, цэцэрлэгийн тоогоо бууруулахгүй нэмэгдүүлэх бодлого бариарай гэдэг чиглэлийг өгч байсан. Энэ дээр нэлээн анхаарч ажиллаарай гэсэн чиглэлийг би та бүхэнд дахиж хэлэх гэж байгаа юм. Сая бол хотод ч тэр хөдөө орон нутаг ч тэр энэ сургууль, цэцэрлэг болоод ЭМТ-үүдийн хүртээмж чанартай холбоотой асуудлуудыг голлож их ярьж байна. Энэ дотроос бас гишүүд яг манай Байнгын хороонд сая орж ирж хэлээгүй ч гэсэн яг хуралдааныг телевизээр үзээд хэлж байхад саналуудыг өөрсдөө явуулж байна. Энэ дээр бол сургуулийн стандартын асуудлуудыг ярьж байна аа. Стандартын гал тогоотой байх асуудлыг хөндөж ярьж байна. Үдийн хоол гээд үдийн хөтөлбөр гээд Боловсролын хуулиараа тавигдсан байгаад байдаг. Гэтэл АХБ-ны энэ зээлийн хэлэлцээрээр шалгуур шаардлага дээр нь магадгүй энэ стандарт шаардлага нь тавигдаагүй ч гэдэг юм уу тийм асуудлууд тусгагдаагүй байж магадгүй байна аа. Энийг бол холбогдох яамдууд дээр анхааруулж хэлж өгөөрэй гэдэг асуудлыг хэлж байна.

Тэгэхээр магадгүй маргааш чуулганаар ороход бол энийг гишүүд нэлээн анхаарч асууж, лавлаж тодруулж тодотгож хэлэх байх гэж бол бодож байна. АХБ-ны энэ зээлээс 20 орчим сая долларыг бол ХАА-н салбарын хүний нөөцийг бэлтгэх сургалтын орчныг сайжруулахад зориулагдах юм байна гээд танилцуулга дээр бол орж ирсэн байсан. Энэн дээр тодорхой байршлыг заасан байсан. Энэ дээр гишүүд нэлээн шүүмжлэлтэй байгаа. Байршлыг заасан дээр.

ХАА-н салбар гэхээр зөвхөн энэ өөрөө газар тариалангийн асуудал биш МАА-н салбарын асуудлууд бүх бүс нутгууд дээр тэгш хүртээмжтэй байх зүйлүүд дээр анхаарах ёстой. Тэгэхээр энэн дээр яг голлож яг зөвхөн эсвэл юу гэдэг юм энэ нь өөрөө зөвхөн газар тариалан байх юм уу, эсвэл зөвхөн юу гэдэг юм онцгой нэг бүс нутаг дээр байх юм уу эсвэл тэр нь МАА дээр байх юм уу энэ бодлогууд дээр нь нэлээн анхаарч ажиллаарай гэдэг чиглэлүүдийг хэлэх байна. Бид нар ер нь энэ салбарынхаа хүний нөөцийг орчин үеийн технологийн дэвшилтэт хослуулж хөгжүүлж бэлтгэх зайлшгүй шаардлага байгаа.

Ингээд гишүүд орж ирсэн байна. Санал хураалтыг явуулъя. Бэлэн бус байгаа гишүүд. Шижир гишүүн та хуруугаа уншуулаарай. Шижир гишүүн таны хуруу уншигдаагүй байна Шижир гишүүн.

Санал хураалтыг явуулъя Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр Соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд саналаа өгнө үү, анхааралтай байгаарай.

Санал хураалт.

58.8 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсэг болоод гишүүддээ баярлалаа.

Маргааш чуулган дээр Байнгын хороо санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах ёстой байгаа. Танилцуулах гишүүн байна уу? Хосбаяр гишүүн илтгэнэ ээ.

Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан байна. Хүрэлцэн ирсэн ажлын хэсэг болоод гишүүдэд дахин баярлалаа. Та бүхэнд бүгдээрэнд нь хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Баярлалаа.

16.10 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА